

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГАД НЭР ДЭВШҮҮЛЭХ ТУХАЙ АСУУДЛААР  
НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 12 дугаар  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Д.Батцогтыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргад улируулан ажиллуулахаар нэр дэвшүүлснийг тус Байнгын хорооны 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батцогтыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргад улируулан ажиллуулахыг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэйгээр дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасны дагуу Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлаар тус Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

**Д.АРВИН**

